



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 7 сарын 06 өдөр

Дугаар А/67

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дах хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дах хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах тухай" 78 тоот зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны "Журам шинэчлэн батлах, журамд өөрчлөлт оруулах тухай" 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам", Монгол Улсын Засгийн газрын 2014 оны "Журам, чиглэл шинэчлэн батлах тухай" 71 дүгээр тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны "Журам батлах тухай" А/316 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутныг сонгон шалгаруулах журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай" 2015 оны А/454 дугаар тушаалын Баярсайхан овогтой Аюуш-д холбогдох хэсгийг Содбаатар овогтой Төгс-Очир Мичиган Стейт их сургууль, Биосистемийн инженер бакалаврт 3 жил, Мөнхбат овогтой Оюунгэрэл-д холбогдох хэсгийг Ариунболд овогтой Чинсанаа Брауч коллеж, Нью Йоркийн Сити их сургууль, санхүү эдийн засгийн бакалаврт 4 жил гэж тус тус өөрчилсүгэй.

2. Баярсайхан овогтой Батцоожийн суралцах хугацааг 1 жилээр сунгасугай.

3. Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Боловсролын зээлийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Олон улсын төсөл, хөтөлбөр гадаад хамтын ажиллагааны газар /Ж.Бямбацогт/-д тус тус даалгасугай.



Г. ЧУЛУУНБААТАР

09 1533